

ХДХВ-ийн халдвартай өвчтөнд үүссэн Капошийн сарком: ЭМНЭЛЗҮЙН ТОХИОДОЛ

П.Үнэнчимэг^{1,2}, Ч.Ууган-Оюун¹, П.Нарантуяа¹, М.Оюунжаргал¹, А.Индра¹, О.Нармандах¹

¹Халдварт Өвчин судлалын Үндэсний Төвийн ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны алба

²Этүгэн их сургууль

Цахим иуудан: unenchimeg5884@gmail.com, Утас: 99185884

Түлхүүр үг:

ХДХВ
Капошийн сарком
Лимфосарком,
Ретровирусийн эсрэг
эмчилгээ
CD4 эс
Хавсарсан хавдар

Товч утга

Удиртгал: Монгол Улсад хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ)-ийн халдвар анх 1992 онд бүртгэгдсэнээс хойш 2025 оны байдлаар нийт 427 тохиолдол бүртгэгдээд байна. Хэдийгээр ХДХВ-ийн тархалт харьцангуй бага хэвээр байгаа боловч дархлаа дарангуйлагдсантай холбоотой дагалдах халдварууд болон хавдрууд, тэр дундаа Капошийн сарком (КС) цөөн тохиолдлоор бүртгэгдсээр байна.


Тохиолдлын танилцуулга: Монгол Улсад Капошийн саркомын нийт 3 тохиолдол (2003, 2010, 2018 онуудад) бүртгэгдсэн бөгөөд үүнээс 2 нь нас барж, 1 тохиолдол нь одоог хүртэл эмчилгээ, хяналтад амьдарч байна. Энэхүү судалгаанд амьд байгаа нэг тохиолдлыг сонгон авч, эмнэлзүйн онцлог, оношилгоо, эмчилгээний явц болон үр дүнг тодорхойлох замаар ретровирусийн эсрэг эмчилгээ болон хавсарсан эмчилгээний ач холбогдлыг харуулахыг зорьсон. Тухайн өвчтөнд ретровирусийн эсрэг эмчилгээ болон хими эмчилгээг хавсран хэрэглэсний үр дүнд дархлааны үзүүлэлт сайжирч, CD4 эсийн тоо нэмэгдэн, хавдрын шинж тэмдгүүд буурсан байна.

Удиртгал: Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ)-ийн халдвартай хүмүүст дархлаа дарангуйлагдсантай холбоотойгоор төрөл бүрийн хавсарсан халдвар болон хавдар үүсэх эрсдэл нэмэгддэг. Тэдгээрээс Капошийн сарком (КС) болон лимфом нь салст бүрхэвчинд нөлөөлдөг хорт хавдрын нэгэн хэлбэр бөгөөд Мориц Капошигийн тодорхойлсноор олон голомтот ангиопрлифератив судасны эмгэг гэж тооцогддог.¹ Ялангуяа вирусийн репликацийг хянаж чадахгүй, CD4 эсийн тоо бага үед ихэвчлэн тохиолддог.² Монгол улсад ХДХВ-ийн халдварын тархалт харьцангуй бага мөн ретровирусийн эсрэг эмчилгээ (РВЭЭ)-г эрт эхэлж байгаатай холбоотой хавсарсан халдварын тоо харьцангуй цөөн хэдий ч ДОХ-ын шалтгаант хавдрын тохиолдлууд бүртгэгдэж байна. Иймд ХДХВ-ийн халдвартай өвчтөнд хавсарсан хавдрын оношилгоо, эмчилгээний үр дүнг судлах нь чухал ач холбогдолтой.

Монгол улсад бүртгэгдсэн ХДХВ-ийн халдвартай өвчтөнд илэрсэн Капошийн саркомын тохиолдлыг танилцуулж, оношилгоо, эмчилгээний явц болон үр дүнг тодорхойлох, мөн ретровирусийн эсрэг эмчилгээ (РВЭЭ)-ний нөлөөг үнэлэх зорилгоор өвчтөний эмнэлзүйн түүх, биеийн үзлэг, лабораторийн үзүүлэлтүүд (CD4 эсийн тоо, вирусийн ачаалал), дүрс оношилгоо болон эмгэг судлалын шинжилгээний хариу, эмчилгээний явц, үр дүнг ХӨСҮТ-ийн эмнэлгийн бүртгэлд тулгуурлан цуглуулж, чанарын аргаар дүн шинжилгээ хийв.

Тохиолдлын танилцуулга: 35 настай, эрэгтэй. 2010 оны 06 сараас амны хөндийд үүсгэвэр илэрч, улмаар олон тоогоор нэмэгдэн томорсон. 2010 оны 07 сард БНСУ-д компьютер томограф (СТ), MRI болон эдийн шинжилгээгээр Капошийн сарком болон лимфосарком оношлогдсон. 2010 оны 09 сарын 02-нд ХӨСҮТ-ийн хяналтад орсон. Асуумжаар өвчтөн нь сүүлийн 10 жилийн хугацаанд Тайвань улсад амьдарч байсан, эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог өгүүлэмжтэй. 2010 оны 10 сарын 22-нд CD4 эсийн тоо 282 эс/мл, вирусийн ачаалал 210,000 хуулбар эс/мл байсан тул ретровирусийн эсрэг эмчилгээг (тенофовир/ ламивудин/эфаверенц) эхлүүлсэн. 2010–2011 онд хими эмчилгээ (DOX, CTX, VCR) 6 удаа орсон. Мэс заслаар арьсны үүсгэвэр авсан. Эмчилгээний үр дүнд Капошийн сарком болон лимфосаркомын тууралтууд шимэгдэн арилсан. 2012 оны 08 сарын 31-нд CD4 эсийн тоо 535 эс/мл болж нэмэгдсэн.

Хэлцэмж: Энэхүү тохиолдол нь ХДХВ-ийн халдвартай өвчтөнд дархлаа дарангуйлагдсантай холбоотой ДОХ тодорхойлогч хавдрууд үүсэх эрсдэл өндөр байдгийг тодорхой харуулж байна. Капошийн сарком нь хүний герпес вирус-8 (HHV-8)-тай холбоотой ангиопрлифератив хавдар бөгөөд дархлааны тогтолцоо сулрах үед идэвхжин илэрдэг.³ Ялангуяа CD4 эсийн тоо буурсан, вирусийн ачаалал өндөр үед Капошийн сарком үүсэх магадлал нэмэгддэг нь олон улсын судалгаагаар нотлогдсон.⁴



Зураг 1. Капошийн Сарком эмнэлзүй. А, В. Амны хөндийд байрласан хавдрын үүсгэвэр. Б. Арьсан дээр гарсан КС. Г. Эмчилгээний дараах байдал

Манай тохиолдолд өвчтөнд Капошийн сарком болон лимфосарком зэрэг хавсарсан хавдрууд зэрэгцэн илэрсэн нь дархлааны гүн дарангуйллыг илтгэж байна. Энэ нь ХДХВ-ийн халдвар удаан хугацаанд оношлогдоогүй, эсвэл эмчилгээ хойшлогдсон байж болзошгүйг илэрхийлж болох бөгөөд клиникийн хувьд хүнд хэлбэрийн явцтайг харуулдаг. Ретровирусийн эсрэг эмчилгээг (РВЭЭ) цаг алдалгүй эхлүүлэх нь ХДХВ-ийн халдвартай өвчтөнд дархлааны үйл ажиллагааг сэргээж, CD4 эсийн тоог нэмэгдүүлэх, вирусийн ачааллыг бууруулах үндсэн арга хэмжээ юм. Энэхүү тохиолдолд РВЭЭ-г эхлүүлсний дараа CD4 эсийн тоо мэдэгдэхүйц нэмэгдсэн нь дархлааны сэргэлт явагдсаныг илтгэж байна.

ХДХВ-ийн халдвартай өвчтөнүүдэд хавсарсан хавдрууд ихэвчлэн хожуу шатанд оношлогдох нь элбэг бөгөөд энэ нь эмчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болдог.⁵ Монгол Улсад Капошийн саркомын тохиолдол цөөн бүртгэгдэж байгаа боловч бүртгэгдсэн тохиолдлуудын дийлэнх нь таагүй төгсгөлтэй байгаа нь эрт илрүүлэг, оношилгооны чадавхыг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Иймээс ХДХВ-ийн халдвартай өвчтөнд тогтмол хяналт хийх, дархлааны үзүүлэлтүүдийг үнэлэх, арьс болон салстын өөрчлөлтийг анхааралтай ажиглах замаар Капошийн сарком болон бусад хавсарсан хавдрыг эрт илрүүлэх нь нэн чухал юм. Мөн эмчилгээг цаг алдалгүй эхлүүлж, олон салбарын хамтарсан менежментийг хэрэгжүүлэх нь өвчтөний амьдралын

чанар, амьд үлдэх хугацааг сайжруулахад чухал ач холбогдолтой.

Дүгнэлт: Энэхүү тохиолдол нь ХДХВ-ийн халдвартай өвчтөнд дархлаа буурснаар ДОХ-ын шалтгаант хавдрууд үүсэх боломж өндөр байдгийг харуулж байна. Ретровирусийн эсрэг эмчилгээ (РВЭЭ)-г цаг алдалгүй эхлүүлсэн нь дархлааг сэргээж, CD4 эсийн тоог нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Мөн хими эмчилгээтэй хавсран хэрэглэснээр хавдрын явцыг бууруулж, эмнэлзүйн сайжралд хүрсэн байна. Олон улсын судалгаагаар РВЭЭ нь Капошийн саркомын явцыг удаашруулах, зарим тохиолдолд бүрэн шимэгдүүлэх нөлөөтэй гэж үздэг. Энэ тохиолдол нь одоог хүртэл ХӨСҮТ-ийн хяналтанд эмчилгээ, тусламж үйлчилгээг авч байгаа нь РВЭЭ болон хавсарсан эмчилгээний үр дүн сайн байгааг баталж байна.

Ном зүй

1. *kaposi-sarcoma-in-hiv-positive-patient-case-report.pdf* doi:10.35248/2684-124X.20.5.164
2. Palich R, Makinson A, Veyri M, et al. Kaposi's Sarcoma in Virally Suppressed People Living with HIV: An Emerging Condition. *Cancers (Basel)*. Nov 15 2021;13(22)doi:10.3390/cancers13225702
3. Mesri EA, Cesarman E, Boshoff C. Kaposi's sarcoma and its associated herpesvirus. *Nat Rev Cancer*. Oct 2010;10(10):707-19. doi:10.1038/nrc2888
4. Costa R, Silva L, Monteiro R, Santos F, Mota M. Kaposi Sarcoma as Presentation of HIV - A Clinical Case. *Cureus*. Oct 2021;13(10):e18936. doi:10.7759/cureus.18936
5. Diakite M, Shaw-Saliba K, Lau CY. Malignancy and viral infections in Sub-Saharan Africa: A review. *Front Virol*. 2023;3doi:10.3389/fviro.2023.1103737

Kaposi's Sarcoma in a patient living with HIV: A case report

Unenchimeg P^{1,2}, Uugan-Oyun Ch¹, Narantuya P¹, Oyunjargal M¹, Indra A¹, Narmandakh O¹

¹AIDS/STI Surveillance and Research Department, National Centre for Communicable Diseases, Mongolia

²School of Medical Sciences, Etugen University

E-mail: unenchimeg5884@gmail.com, Tel: +976-99185884

Abstract

Background: People living with human immunodeficiency virus (HIV) are at increased risk of developing opportunistic infections and malignancies due to immunosuppression. Among these, Kaposi's sarcoma (KS) and lymphoma are malignant conditions affecting mucocutaneous tissues and are considered multifocal angioproliferative disorders, as originally described by Moritz Kaposi. These conditions are more likely to occur in individuals with uncontrolled viral replication and low CD4 cell counts. In Mongolia, although the overall prevalence of HIV infection remains low and early initiation of antiretroviral therapy (ART) has reduced the incidence of opportunistic infections, cases of AIDS-related malignancies continue to be reported. Therefore, evaluating the clinical presentation, diagnosis, and treatment outcomes of malignancies in HIV-infected patients is of significant importance.

Aim: To present a case of Kaposi's sarcoma in a patient living with HIV in Mongolia, and to describe the clinical course, diagnostic findings, treatment outcomes, and the impact of antiretroviral therapy (ART).

Materials and Methods: This case report is based on a descriptive analysis of a single patient. Clinical data, including medical history, physical examination findings, laboratory parameters (CD4 cell count and viral load), imaging studies, histopathological results, treatment course, and outcomes were collected from the medical records of the National Center for Communicable Diseases and analyzed qualitatively.

Case Presentation: A 35-year-old male patient presented with oral lesions that first appeared in June 2010 and progressively increased in number and size. In July 2010, he underwent computed tomography (CT), magnetic resonance imaging (MRI), and histopathological examination in the Republic of Korea, which confirmed the diagnosis of Kaposi's sarcoma and lymphosarcoma. The patient was enrolled in care at the National Center for Communicable Diseases on September 2, 2010. According to his history, he had lived in Taiwan for the past 10 years and reported having sex with men. On October 22, 2010, his CD4 cell count was 282 cells/ml and viral load was 210,000 copies/ml. Antiretroviral therapy (tenofovir/lamivudine/efavirenz) was initiated. Between 2010 and 2011, he received six cycles of chemotherapy (DOX, CTX, VCR), and surgical excision of skin lesions was performed.

Following treatment, the Kaposi's sarcoma and lymphosarcoma lesions regressed significantly. By August 31, 2012, his CD4 cell count had increased to 535 cells/ μ L.

Conclusion: This case demonstrates that HIV-infected patients are at high risk of developing AIDS-defining malignancies due to immunosuppression. Early initiation of antiretroviral therapy (ART) played a crucial role in immune restoration, as evidenced by the increase in CD4 cell count. In addition, combined treatment with chemotherapy contributed to tumor regression and clinical improvement.

Keywords: HIV, Kaposi's Sarcoma, Lymphosarcoma, Antiretroviral therapy, CD4 cell,